



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэхь заалт, "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголын хөрөнгийн биржийн гишүүн "Би ди сек ҮЦК" ХК нь Үйлчилгээ үзүүлэх гэрээнд туссан нэмэлт төлбөрүүд төлөөгүй тул үнэт цаасны арилжаанд оролцох "BDSC1.GM, BDSC2.GM" эрхүүдийг үүрэг биелэх хүртэл хугацаанд түдгэлзүүлсүгэй.
2. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх эрхийг түдгэлзүүлэхийг Үйл ажиллагааны газрын Арилжаа бүртгэлийн алба /Д.Тогтохбаяр/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

000092